

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
сарын ..-ний өдөр

Улаанбаатар хот

ХОТ, СУУРИНЫ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хот, суурины ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, ашиглах, арчлах, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавихтай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Хот, суурины ногоон байгууламжийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн хамрах хүрээ

3.1. Монгол Улсын хот, суурины эдэлбэр газарт хамаарах ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, арчлах, хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулахад өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй энэ хууль үйлчлэнэ.

3.2. Хот, суурины ногоон бүсэд хамаарагдах хамгаалалтын ой, байгалийн унаган төрх бүхий ногоон байгууламжтай холбогдох харилцааг Ойн тухай хуулиар зохицуулна.

3.3. Ногоон байгууламж дахь ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал зэргээс хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавихтай холбогдсон үйл ажиллагааг Ургамал хамгааллын тухай хууль тогтоомжоор зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1 “Ногоон байгууламж” гэж хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төслийн дагуу –архитектур-орон зайн тааламжтай орчин бүрдүүлэх, дуу чимээг намсгах, агаар, ус, хөрсний бохирдлыг багасгах, байгалийн тэнцэл алдагдах, гамшгаас сэргийлэх зорилгоор байгуулсан амьд мод, бут сөөг, өвслөг ургамал, цэцэг, зориулалтын барилга байгууламжийн зохицол бүхий цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, цэцэрлэгжүүлсэн гудамж, зам, талбай, биейн тамир спорт, хүүхдийн тоглоомын талбай, ногоон зурвас болон байгалийн унаган төрхийг ашиглан байгуулсан нэгдлийг;

4.1.2. “Цэцэрлэгт хүрээлэн” гэж хот, сууринд иргэдийн ая тухтай амрах, зугаалах, чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх таатай орчин, нөхцлийг бүрдүүлсэн нийтийн соёл, спорт амралт, зугаалгын, аялал жуулчлалын, танин мэдэхүйн чиглэлээр байгуулсан байгаль-экологийн ногоон байгууламжийг бүрдүүлсэн цогцолборыг

4.1.3. “бичил цэцэрлэг” гэж иргэдийн ая тухтай амрах, зугаалах, чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх бичил уур амьсгалыг орчинг бүрдүүлсэн олон нийтийн, үйлдвэрлэл

¹ Монгол Улсын Үндсэн хууль –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны №1

үйлчилгээний барилга байгууламж, орон сууцны хороолол, цогцолбор хооронд болон олон нийтийн бусад шаардлагатай газарт байгуулсан ногоон байгууламжийг;

4.1.4. "Тусгай зориулалтын" ногоон байгууламж гэж эрдэм шинжилгээ, судалгааны цэцэрлэгт хүрээлэн, мод үржүүлгийн газар, үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар байгуулсан

4.1.5. "Ногоон зурвас" гэж хот, суурины гудамж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудлын зурвас газар, үйлдвэрлэлийн бүс, хог хаягдлын цэг, нийтийн аж ахуй, агуулахын зориулалттай барилга байгууламж, оршуулгын газар зэрэг тусгай зориулалтын үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламжийг олон нийт, орон сууцны бүсээс тусгаарлах болон дуу чимээ, утаа тоосжилтоос хамгаалах зорилгоор байгуулсан ногоон байгууламжийг;

4.1.6. "Ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөө" гэж тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, арчлах, хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогцоор нь, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг;

4.1.7. "Ногоон байгууламжийг арчлах" гэж ногоон байгууламжид шаардлагатай байнгын болон өвчин, хөнөөлт шавж, түймэр, байгалийн онц, ноцтой, гамшигт үзэгдэл, хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас ногоон байгууламжид үүсч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн технологийн дагуу хийж гүйцэтгэх арга хэмжээг;

4.1.8. "Ногоон байгууламжийг хамгаалах" гэж ногоон байгууламжийн төлөв байдалд сөрөг нөлөө үзүүлэх хүний болон байгалийн хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ногоон байгууламжийн нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах, нөхөн сэргээх, хорио цээр тогтоох, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг;

4.1.9. "Ногоон байгууламжийн үйл ажиллагаа" гэж ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, арчлах хамгаалах, нөхөн сэргээх, дагалт баялгийг ашиглах үйл ажиллагаа, ургамлын нөөцийг бүрдүүлэх зорилго бүхий технологийн парк, үржүүлгийн газар, хүлэмжийн аж ахуйтай холбогдох цогц үйл ажиллагааг;

5 дугаар зүйл. Ногоон байгууламжийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Хот, суурины ногоон байгууламжийн үйл ажиллагаанд талаар дараах зарчмыг баримтлана.

5.1.1. ногоон хөгжлийн бодлогод нийцсэн байх;

5.1.2. олон нийтийн оролцоог хангах, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн идэвх, оролцоог урамшуулах, хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх;

5.1.3. ногоон байгууламжийн тоо, хэмжээг нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлттэй уялдуулан байнга нэмэгдүүлэх;

5.1.4. тухайн хот, суурины ногоон байгууламж дахь ургамлын амьдрах чадварыг сайжруулан, төрөл, зүйлийн бүрдлийг баяжуулах;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ногоон байгууламжийн үүрэг зориулалт, ангилал, байршил, бүрэлдэхүүн

6 дугаар зүйл. Ногоон байгууламжийн үүрэг зориулалт

6.1. Ногоон байгууламж нь дараах үүрэг, зориулалттай байна.

6.1.1. хүн амын ажиллаж, амьдрах эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх;

6.1.2. агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах;

6.1.3. дуу чимээг багасгах;

6.1.4. уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлэх;

6.1.5. хот, суурины архитектур - орон зайн бичил уур амьсгал, гоо зүй, чимэглэл бүхий тааламжтай орчинг бүрдүүлэх;

6.2. Ногоон байгууламжийг онц байдал зарласан үед болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд аюул бүхий нутаг дэвсгэрээс хүн, мал, амьтан, эд баялгийг түр нүүлгэн шилжүүлж байрлуулах зориулалтаар ашиглаж болно.

7 дугаар зүйл. Ногоон байгууламжийн ангилал

7.1. Ногоон байгууламжийг үүрэг, зориулалтаар нь нийтийн хэрэгцээний, хязгаарлагдмал хэрэгцээний, тусгай зориулалтын, байгалийн унаган төрх байдлыг хадгалсан гэж ангилна.

7.2. Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж нь дотроо олон нийтийн, дурсгалт цэцэрлэг гэж ангилагдах ба нийтийн цэцэрлэгт хот, суурины нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, биеийн тамир, спорт, хүүхдийн тоглоомын талбай бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн, оршин суугчдад зориулсан орон сууцны цэцэрлэг, явган зорчигч болон бусад зорчигчдод зориулсан цэцэрлэгт талбай, цэцэрлэгт гудамж зэрэг хамаарна. Дурсгалт цэцэрлэг гэдэг нь нийтийн хэрэгцээнээс бусад зорилгоор байгуулсан цэцэрлэгийг хэлэх ба үүнд түүхийн, соёлын, гол горхи, нуур цөөрмийн эрэг дагуух, оршуулгын, биеийн тамирын гэх мэт цэцэрлэгүүд байна.

7.3. хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжид үйлдвэрийн барилгын эдэлбэр газарт байгуулсан бичил цэцэрлэг болон хот, суурины гудамж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудлын зурвас газар, үйлдвэрлэлийн бүс, хатуу хог хаягдлын цэг, нийтийн аж ахуй, агуулахын зориулалттай барилга байгууламж, оршуулгын газар зэрэг тусгай зориулалтын үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламжийг олон нийт, орон сууцны бүсээс тусгаарлах болон дуу чимээ, утаа тоосжилтоос хамгаалах зорилгоор байгуулсан ногоон зурвас хамаарна.

7.4. тусгай зориулалтын ногоон байгууламжид ботаник цэцэрлэг, модлог ургамлын цэцэрлэг зэрэг ургамлыг тарималжуулах, нутагшуулах, шинэ сорт гаргаж авах, ургамлын төрөл, зүйлийг хамгаалахтай холбогдсон судалгаа, шинжилгээний зориулалттай болон хөрсний эвдрэл, элсний нүүлт, хүчтэй салхи, элс, цасны хунгарлалтаас хамгаалах, гол горхи, нуур цөөрмийн эргийн хамгаалалтын ногоон зурвас хамаарна.

7.5. байгалийн төрх байдлын ногоон байгууламжид байгалын унаган төрхийг түшиглэн ойн нөөц, дагалт баялгийг ашиглахаас өөрөөр иргэдийн амралт зугаалга, аялал жуулчлалын зориулалтаар ашиглах бүс нутагт байгуулсан ногоон байгууламж хамаарна. **байгалийн төрх байдлын ногоон байгууламжид гэдгийг Ойн тухай хуультай уялдуулах**

7.6. Нийтийн хэрэгцээний, тусгай зориулалтын болон байгалийн унаган төрх байдлыг хадгалсан ногоон байгууламж нь төрийн нийтийн зориулалттай өмч байна.

8 дугаар зүйл. Ногоон байгууламж байгуулах газар, байршил

8.1. Ногоон байгууламжийг хот, суурины онцлог, оршин суугчдын тоо, хэмжээнээс хамаарч харилцан адилгүй хэмжээнд төлөвлөж байгуулна.

8.2. Ногоон байгууламжийг хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу дараах нутаг дэвсгэрт холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандартад нийцүүлэн төлөвлөж байгуулна.

8.2.1. хот, суурины нийтийн эдэлбэр газар;

8.2.2. амралт, аялал жуулчлалын бүс;

8.2.3. авто зам, төмөр замын зурвас газар;

8.2.4. хөрсний эвдрэл, элсний нүүлт, хүчтэй салхи, элс, цасны хунгарлалтаас хамгаалах шаардлагатай газар;

8.2.5. усны эх үүсвэр, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс;

8.2.6. ботаник цэцэрлэг, модлог ургамлын цэцэрлэг, ногоон байгууламжийн үйл ажиллагаанд холбогдох эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны зориулалтаар олгосон бусад газар;

8.2.7. иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газар болон барилга байгууламжийн орчин;

8.2.8. барилга байгууламжийн дотор орон зай болон дээвэр, хана;

8.2.9. бусад шаардлагатай газар.

8.3. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажих талбайг түр, нөөцлөгдөх болон барилгажихгүй талбайд байнгын болон түр ногоон байгууламж байгуулна.

8.4. Ногоон байгууламжийн байршлыг газрын гадаргуу, хөрсний онцлогт тохируулан тухайн газар нутаг дахь түүх, соёлын дурсгалт зүйл, ард иргэдийн зан заншил, уламжлал зэрэг байгаль, нийгэм, соёлын нөхцлийг харгалзан тогтооно.

9 дүгээр зүйл. Ногоон байгууламжийн бүрэлдэхүүн

9.1. Энэ хуулийн 7.2-д заасан ногоон байгууламж нь амьд мод, бут, сөөг, өвслөг ургамал, цэцэг зэрэг зөөлөн ландшафт, усан толио, усан оргилуур, архитектурын жижиг элемент, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн тоноглол, зориулалттай байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, дугуй болон явган зам, сүүдрэвч, сандал, гэрэлтүүлэг зэрэг хатуу ландшафтыг зохистой хослуулсан байна.

9.2. Энэ хуулийн 7.3-т заасан ногоон байгууламж нь амьд мод, ургамлын зохицол бүхий олон төрлийн цэцэг, ургамал, мод, бут, сөөг болон зориулалтаасаа хамааруулан тохижуулсан зам, талбай, байгууламжтай байна.

9.3. Энэ хуулийн 7.4-т заасан ногоон байгууламжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай нөхцөлд тухай бүр барьж байгуулна.

9.4. Ногоон байгууламж нь газар эдэлбэрийн чиглэл, ургамлын бүс бүслүүрийн онцлогт зохицох, арчилгаа бага шаардах ургамлын төрөл, зүйлээс бүрдсэн, орчиндоо дасан зохицсон байна.

9.5. Биеийн тамир, спортын зориулалттай барилга байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, дугуй болон явган зам, сүүдрэвч, сандал, гэрэлтүүлэг зэрэг хатуу ландшафтын эзлэх талбай тухайн цэцэрлэгт хүрээлэнгийн газар нутгийн 30 хувиас ихгүй байна.

9.6. Шинээр төлөвлөгдсөн барилга байгууламжийн нийт талбайн 20-оос доошгүй хувийг ногоон байгууламж байхаар ерөнхий төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн болон хот, тосгоны удирдах байгууллагын бүрэн эрх

10 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

10.1. Улсын Их Хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

10.1.1. ногоон байгууламжийн үйл ажиллагааны талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

10.1.2. ногоон байгууламжийн талаарх хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

10.1.3. ногоон байгууламжийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлах;

10.1.4. энэ зүйлийн 10.1.3-т заасан үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүрийн Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд батлах;

10.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

11.1. Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

11.1.1. ногоон байгууламжийн үйл ажиллагааны талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

11.1.2. улсын хэмжээний ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэнд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх;

11.1.3. Хуульд заасан бусад эрх.

12 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

12.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12.1.1. ногоон байгууламжийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ;

12.1.2. улсын хэмжээний ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ургамалжилтын бүс, бүслүүрт тохируулан боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах;

12.1.3. ногоон байгууламжийг байгуулах, арчлах, хамгаалах, ашиглах, устгах, буулгах, нөхөн сэргээхтэй холбогдсон дүрэм, журам, стандартыг хууль тогтоомжид заасны дагуу дангаараа болон холбогдох бусад байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх;

12.1.4. ногоон байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг болох мод, бут, сөөг, ургамлын үрийн нөөцийн сан бүрдүүлэх, үржүүлгийн газар байгуулах ажлыг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах;

12.1.5. ногоон байгууламжийг байгуулах, арчлах, хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, цуцлах;

12.1.6. ногоон байгууламжийн төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, ашиглалт, хамгаалалтын байдлыг хянах;

12.1.7. ногоон байгууламжид учруулсан хохирлын хэмжээг тодорхойлох, ногоон байгууламжийн экологи - эдийн засгийн үнэлгээ тогтоох журмыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах;

12.1.8. ногоон байгууламжийн мэдээллийн улсын нэгдсэн сан бүрдүүлэх;

12.1.9. ногоон байгууламж байгуулах, хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;

12.1.10. иргэдэд ногоон байгууламжийн үйл ажиллагааны талаар мэдлэг олгох сургалт, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх арга хэмжээг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

12.1.11. ногоон байгууламжийн үйл ажиллагааны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих;

12.1.12. ногоон байгууламжийн үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12.1.13. ногоон байгууламжийн бүртгэл, тооллого хийх журмыг батлах;

12.1.14. ногоон байгууламжийн экологи - эдийн засгийн үнэлгээ тогтоох журмыг батлах;

13.1.15. ногоон байгууламжийн төлөвлөлт, холбогдсон салбар хоорондын үйл ажиллагааны харилцан уялдааг хангаж, хэрэгжилтэд хяналт тавих.

12.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хот, суурины ногоон байгууламжийн асуудал хариуцсан нэгж ажиллана.

13 дугаар зүйл. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

13.1. Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

13.1.1. хот, суурины ногоон байгууламжийн төлөвлөлтийн норм, дүрэм, журам, зааврыг батлах;

13.1.2. хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, барилга байгууламжийн зураг төсөлд ногоон байгууламжийг норм, дүрэм, журам, зааврын дагуу тусгуулан, хэрэгжилтийг хангуулах;

13.1.3. хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, барилга байгууламжийн зураг төслийн дагуу ногоон байгууламжийг байгуулсан ажлын хэрэгжилтийн талаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайланг жил бүр хэлэлцэх;

13.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

14 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх, үүрэг

14.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.1.1. улсын хэмжээний ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

14.1.2. ногоон байгууламж байгуулах, арчлах, хамгаалах, нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг батлах, биелэлтэнд хяналт тавих;

14.1.3. нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ногоон байгууламжийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.4. энэ хуулийн 12.1.7-д заасны дагуу ногоон байгууламжийг нөхөн сэргээхэд шаардагдах зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох;

14.1.5. ногоон байгууламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг батлах;

14.1.6. хот, суурины ерөнхий төлөвлөгөөнд ногоон байгууламж байгуулахаар тусгагдсан эсхүл байгуулсан газрыг өөр зориулалтаар ашиглуулах, эзэмшүүлэхээр өөрчлөхийг хориглох, хэрэв ашиглуулах, эзэмшүүлэхээр зөвшөөрөл олгогдсон бол зөвшөөрлийг цуцлах;

14.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

15.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

15.1.1. хот, тосгоны ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах;

15.1.2. ногоон байгууламж байгуулах, арчлах, хамгаалах, нөхөн сэргээх зориулалтаар улсын болон орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнах;

15.1.3. ногоон байгууламжийн үйл ажиллагааны тайланг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, байгаль орчны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр хүргүүлэх;

15.1.4. хот, суурины нутаг дэвсгэрт ногоон байгууламжийн тооллого, бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх;

15.1.5. нутаг дэвсгэртээ шинээр баригдах барилга байгууламжийг стандарт, норм, дүрмийн шаардлагад нийцсэн ногоон байгууламж байгуулах, өмнө байсан ногоон байгууламжийн тоо, хэмжээг бууруулахгүй байх шаардлага тавих;

15.1.6. ногоон байгууламжийн үйл ажиллаганы төлөвлөгөөг хот тосгоны удирдлагын саналыг үндэслэн боловсруулж Засгийн газраар батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

15.1.7. Ногоон байгууламжид тарьсан модонд уг модны тухай мэдээллийг агуулсан бар код бүхий паспорт зүүж бүртгэлжүүлэх;

15.1.10. Ногоон байгууламжийн арчилгааны зардлыг тухайн аймаг, сум орон нутгийн төсөвт тусгаж байх түүнчлэн Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлд 31.1-д заасны дагуу цуглуулсан хөрөнгийг /иргэн 16 насанд хүрсэн иргэн 1, аж ахуйн нэгж байгууллага 5-аас доошгүй модыг тариулах, өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана/ тусгай дансанд төвлөрүүлэн зарцуулах

15.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

15.2. Аймаг, нийслэл нь хот, суурины ногоон байгууламжийн асуудал эрхэлсэн бүтэц, нэгжтэй байна.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн ногоон байгууламжийн асуудал эрхэлсэн нэгж түүний нийтлэг эрх, үүрэг

16.1. Аймаг, нийслэлийн ногоон байгууламжийн асуудал эрхэлсэн нэгж нь дараах нийтлэг эрх, үүрэг хүлээнэ:

16.1.1. ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хот суурины удирдлагын саналыг үндэслэн боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

16.1.2. Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу жил бүр мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулж, ногоон байгууламжийг тогтмол нэмэгдүүлэх;

16.1.3. ногоон байгууламж байгуулах, арчлах, хамгаалах, нөхөн сэргээх талаар төрийн болон орон нутгийн удирдах байгууллагаас гаргах шийдвэрт санал оруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

16.1.4. нутаг дэвсгэрийнхээ оршин суугчдын саналыг авсны үндсэн дээр ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах асуудлыг санаачлан зохион байгуулах;

16.1.5. ногоон байгууламжийн төлөв байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх, хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнг ногоон байгууламжийн мэдээллийн санд оруулах;

16.1.6. ногоон байгууламж байгуулах, арчлах, ашиглах, хамгаалах талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан санал санаачлага, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

16.1.7. хот, суурины хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **Цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллага, иргэн, хуулийн** **этгээдийн эрх, үүрэг**

17 дугаар зүйл. Цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа

17.1. Ногоон байгууламжийг байгуулах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах эрх авсан аж ахуйн нэгж, байгууллагыг цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллага гэнэ.

17.2. Энэ зүйлийн 17.1-д заасан байгууллага нь өмчийн аль ч төрөл, хэлбэртэй байж болно.

17.3. Энэ зүйлийн 17.1-д заасан байгууллага дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

17.3.1. ногоон байгууламжийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, байгуулах;

17.3.2. ногоон байгууламж, түүний тодорхой хэсгийг гэрээгээр ашиглаж, ногоон байгууламжийн чиглэлээр үйл ажиллагааг явуулах;

17.3.3. байгууллага, иргэдэд ногоон байгууламжийн үйл ажиллагааны талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;

17.3.4. өөрийн гүйцэтгэсэн ажлын чанар, үр дүнг хариуцаж, үйл ажиллагааныхаа талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах.

17.4. Цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлагыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

18 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг

18.1. иргэн, хуулийн этгээд нь ногоон байгууламжийн талаар холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах нийтлэг үүргийг хүлээнэ.

18.1.1. ногоон байгууламжийн талаарх хууль тогтоомж, хот, тосгоны удирдлагаас гаргасан шийдвэр, холбогдох шаардлагыг биелүүлэх;

18.1.2. хот, суурины нутаг дэвсгэрт газар эзэмшигч бүр хот төлөвлөлтийн стандарт, норм, дүрмээр тогтоосон шаардлагын дагуу эзэмшил газар, барилгын орчин тойрныг ногоон байгууламжтай болгох;

18.1.3. ногоон байгууламжийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, зохистой ашиглах, хайрлан хамгаалах, түүний ургаж үржих хэвийн нөхцөл байдлыг хангах, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах;

18.1.4. ногоон байгууламжийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, устгаж сүйтгэсэн зөрчлийн талаар холбогдох байгууллага албан тушаалтанд мэдэгдэх, үүнтэй холбогдолтой нууцлалыг хадгалуулах;

18.1.5. барилга, байгууламж, зам, инженерийн шугам сүлжээг төлөвлөх, зураг төсөл зохиох, бүтээн байгуулалтын болон засвар үйлчилгээний ажил гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зөвшөөрөл авах, ногоон байгууламжид хохирол учруулахаас сэргийлэх, хохирол учруулсан нөхцөлд ногоон байгууламжийг нөхөн сэргээж, ногоон байгууламжийн экологи, эдийн засгийн үнэлгээний дагуу нөхөн төлбөр төлөх;

18.1.6. үр хүүхэддээ ногоон байгууламжийг хамгаалах, хөгжүүлэх, экологийн хүмүүжил олгох;

18.1.7. сайн дурын үндсэн дээр нийтийн хэрэгцээний болон бусад төрлийн ногоон байгууламжид асуудал хариуцсан этгээдтэй зөвшилцөн мод, суулгац тарих, цэцэрлэгжүүлэх;

18.1.8. хот, суурины удирдлагаас нутаг дэвсгэрийнхээ ногоон байгууламжийг хөгжүүлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлэх.

18.1.9. ногоон байгууламжийн бүртгэл мэдээллийн санд шаардлагатай мэдээллийг тухай бүр өгөх;

18.2. Хуулийн этгээд нь энэ хуулийн 18.1- д зааснаас гадна дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

17.2.1. ногоон байгууламжид шинэ технологи нэвтрүүлэх, эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан химийн бодис, бордоог хэрэглэх

17.2.4. мод, бут, сөөг нутагшуулах, шилжүүлэн суулгах тарималжуулах туршилт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр тариалалт хийх;

ТАВДУГААР БҮЛЭГ

Ногоон байгууламжийг ашиглах, хамгаалах, арчлах, нөхөн сэргээх, нөхөн төлбөр, ногоон байгууламжид хориглох үйл ажиллагаа, олон нийтийн оролцоо

19 дүгээр зүйл. Ногоон байгууламжийн ашиглах, хамгаалах, арчлах

19.1. Нийтийн хэрэгцээний болон байгалийн унаган төрх байдлыг хадгалсан ногоон байгууламжийг аймаг, нийслэлийн асуудал хариуцсан холбогдох бүтэц, нэгж, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийг эзэмшиж, ашиглаж буй иргэн, хуулийн этгээд орон сууцны хороолол, цогцолборын ногоон байгууламжийг Сууц өмчлөгчдийн холбоо, оршин суугчид хариуцаж зориулалтын дагуу ашиглаж хамгаална.

19.2. ногоон байгууламжийн талаарх холбогдох тайлан мэдээг энэ хуулийн 16.1-д заагдсан нэгжид жил бүр хүргүүлж байна

19.3. Ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт, арчилгааг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу зохион байгуулна.

19.4. Нийтийн хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийг хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, үүссэн голомтыг устгах арга хэмжээг Ойн тухай, Ургамал хамгааллын тухай хуулиудад заасны дагуу зохион байгуулна.

19.5. Импортоор оруулж байгаа модлог ургамалыг хязгаарлаж МҮГ-т нутагшуулж цэцэрлэгжилтэнд шилжүүлэх.

20 дугаар зүйл. Ногоон байгууламжийг нөхөн сэргээх, нөхөн төлбөр

20.1. Нийтийн хэрэгцээний, байгалийн унаган төрх байдлыг хадгалсан, тусгай зориулалтай ногоон байгууламжийг нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг улсын, орон нутгийн төсөв, ногоон байгууламжийн сан, бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

20.2. Барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилтын ажлыг гүйцэтгэх явцад учруулсан хохирлыг тухайн үйл ажиллагааг гүйцэтгэсэн этгээд холбогдох хууль, тогтоомжийн дагуу нөхөн төлнө.

20.3. Ногоон байгууламжийг нөхөн сэргээх үйл ажиллагааг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ

20.4. инженерийн дэд бүтцийн төслүүдийг гүйцэтгэхэд захиалагч этгээд энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан нэгжээс зөвшөөрөл авна

20.5. Байгаль орчны хяналтын улсын байцаагч нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавина.

21 дүгээр зүйл. Ногоон байгууламжид хориглох үйл ажиллагаа

21.1. Нийтийн хэрэгцээний, тусгай зориулалтын, байгалийн унаган төрх байдлыг хадгалсан ногоон байгууламжийн нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагааг хориглоно.

21.1.1. ногоон байгууламжийг зориулалтын бусаар ашиглах, устгах, барилга барихыг;

21.1.2. холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгалийн ойгоос том болон зулзагана мод, модлог ургамлыг шилжүүлэн суулгах;

21.1.3. ногоон байгууламжийн талбайд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтгүйгээр стандартын бус, импортын тарьц, суулгацыг нутагшуулах, тарималжуулах, тарих;

21.1.4. мод бут, сөөг, байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний ургамлыг зүй бусаар түүж бэлтгэх, ашиглах;

21.1.5. хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис, биологийн бэлдмэл хэрэглэх;

21.1.6. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр худалдаа үйлчилгээ эрхлэх, зар сурталчилгааны самбар байрлуулах;

21.1.7. батлагдсан зураг төсөлгүйгээр тохижилтын ажил гүйцэтгэх;

21.1.8. ногоон байгууламжийн орц гарц, замыг хаах.

22 дугаар зүйл. Олон нийтийн оролцоо

22.1. Ногоон байгууламжийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана.

22.1.1. ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, арчлах хамгаалах, нөхөн сэргээхэд оновчтой саналыг тусгах;

22.1.2. ногоон байгууламжийг төлөвлөх, байгуулах, арчлах, хамгаалах, нөхөн сэргээх ажилд шаардлагатай нөхцөлд татан оролцуулах;

22.1.3. сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

22.2. Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

23 дугаар зүйл. Ногоон байгууламжид тавих төрийн хяналт

23.1. Ногоон байгууламжийг байгуулах, ашиглах, нөхөн сэргээх, хамгаалахад тавих хяналтыг эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

23.2. Ногоон байгууламжид тавих төрийн хяналтыг Байгаль орчны тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Ойн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, норм, дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ Ногоон байгууламжийн бүртгэл, мэдээллийн сан

24 дүгээр зүйл. Ногоон байгууламжийн бүртгэл, мэдээллийн сан

24.1. Ногоон байгууламжийн байршил, хил зааг, талбай, эзлэхүүн, ургамлын төрөл зүйл, тоо хэмжээ, төлөв байдлын талаарх мэдээллийг багтаасан бүртгэл, мэдээллийн сантай байна.

24.2. Ногоон байгууламжийн нэгдсэн мэдээллийн санг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хот, суурины ногоон байгууламжийн бүртгэл, мэдээллийн санг аймаг, нийслэл, сум дүүргийн ногоон байгууламжийн асуудал эрхэлсэн нэгж эрхлэн хөтөлнө.

24.3. Ногоон байгууламжийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь хот, суурины ногоон байгууламжид хийгдэх тооллогын дүнд үндэслэх бөгөөд тооллого хийх хугацаа, журам, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхтэй холбогдсон журам, зааврыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

24.4. Ногоон байгууламжийн бүртгэл, мэдээллийн санг ногоон байгууламжийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, ногоон байгууламжийн удирдлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ногоон байгууламжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах зэрэгт ашиглана.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Санхүүжилт, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг, Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

25 дугаар зүйл. Ногоон байгууламжийн үйл ажиллагааны санхүүжилт

25.1. аймаг, нийслэлийн Засаг дарга нь ногоон байгууламжийн сантай байна

25.2. сангийн үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан журмаар зохицуулна

25.3. ногоон байгууламжийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг дараах байдлаар шийдвэрлэнэ:

25.3.1. улсын болон орон нутгийн төсөв;

25.3.2. орон нутгийн хөгжлийн сан;

25.3.3. Засгийн газрын байгаль хамгаалах тусгай сан;

25.3.4. гадаад улс, олон улсын байгууллагын хандив тусламж, төсөл, хөтөлбөрийн

санхүүжилт;

25.3.5. бизнес, хувийн хэвшлийн байгууллагаас гаргах хөрөнгө;

25.3.6. бусад эх үүсвэр.

26 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг

26.1. Ногоон байгууламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд дараах дэмжлэг үзүүлнэ:

26.1.1. иргэнд Хувь хүний орлогын албан татварын тухай, хуулийн этгээдэд Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн дагуу орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

26.1.2. элэгдэл, эвдрэлд орж ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, ногоон байгууламж байгуулсан бол Газрын тухай хуулийн² 27.5, 27.6-д заасны дагуу давуу эрхээр эзэмших эрх олгох;

26.1.3. тусгай зориулалтын ногоон байгууламж, эрдэм шинжилгээ, судалгааны технологийн парк Газрын төлбөрийн тухай хуулийн³ 8.2-т заасны дагуу газрын төлбөрөөс чөлөөлөх;

³ Газрын төлбөрийн тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1997 оны №5

26.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас цэцэрлэгжүүлсэн талбай, ногоон байгууламжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хот, тосгоны нийтийн хэрэгцээнд худалдан авах;

26.1.5. ногоон байгууламжийн үйл ажиллагаанд орчин үеийн, шинэ дэвшилттэй арга ажиллагаа нэвтрүүлсэн иргэн, хуулийн этгээдэд холбогдох журмын дагуу урамшуулал олгох.

26.1.6. ногоон байгууламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, хуулийн этгээдэд хөнгөлөлттэй зээл, тусламж олгох зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

27 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

27.1. Ногоон байгууламжийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд зөрчлийн шинж байдал, хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

27.2. Ногоон байгууламжийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий ажилтан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

26.2.1. барилга, хот байгуулалтын журам зөрчиж зөвшөөрөлгүйгээр ногоон байгууламжийн талбай дээр барилгын ажил гүйцэтгэсэн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг жараас наяд дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож газар чөлөөлүүлэх, нөхөн сэргээх, түүнтэй холбогдон гарах зардлыг төлүүлэх, Барилгын тухай хуулийн 20.8-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах;

27.2.2. ногоон байгууламжийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсны дараа ногоон байгууламжийг нөхөн сэргээж хэвийн байдалд оруулаагүй эсвэл дутуу, чанаргүй гүйцэтгэсэн бол зөрчил гаргасан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчөөс жар дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулж, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх;

27.2.3. ногоон байгууламжид хог хаягдал ил задгай асгах, гал түлэх, орчин тойрноо бохирдуулах зэргээр ариун цэврийн шаардлага, галын аюулгүй байдлыг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож зөрчлийг арилгуулж, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх;

27.2.4. Гарцгүй газраар ногоон байгууламж, зүлгэн дээгүүр явсан иргэнийг 5000-10000 төгрөг, тээврийн хэрэгслийн жолоочийг Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу 20000-50000 төгрөгөөр торгоно;

27.2.5. Мод сөөгийн мөчир хугалж гэмтээх, цэцэг таслах зэргээр ногоон байгууламжид хохирол учруулсан хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, иргэдийг 5000-10000 төгрөгөөр торгоно;

27.2.6. Ногоон байгууламжид ургаж байгаа 1 модыг огтлосон иргэн 3, аж ахуйн нэгж, байгууллага 25 болгож нөхөн тарина;

27.2.7. Энэ хуулийн 14.1.6-д заасныг зөрчин зөвшөөрөл олгогдсон бол зөвшөөрлийг хүчингүй болгон, шийдвэр гаргасан тухайн албан тушаалтанд захиргааны хариуцлага хүлээлгэнэ

27.2.8. Энэ хуулийн 21.1.1, 21.1.7-д заасныг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчөөс жар дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулж, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх;

27.2.9. Энэ хуулийн 21.1.2, 21.1.3, 21.1.5-д заасныг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавиас дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулж, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх;

27.9.10. Энэ хуулийн 21.1.4, 21.1.6, 21.1.8-д заасныг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр, хуулийн этгээдийг тавиас дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулж, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх;

ГАРЫН ҮСЭГ